


ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: ДНБ, УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ХУДАЛДАА, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ

Эдийн засгийн өсөлт 11.7%


(2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр)

ДНБ 2013 оны эцэст оны үнээр 17.5 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 25.2%, харин 2005 оны зэрэгцүүлэх үнээр 6.1 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 11.7% тус тус өссөн байна. ДНБ-ий 4 улирлын бодит өсөлт (2005 оны зэрэгцүүлэх үнээр) өмнөх оны мөн үеэс 12.3% өсчээ.




Төсвийн алдагдал 64 тэрбум төгрөгт хүрэв.

Улсын нэгдсэн төсвийн орлого 2014 оны эхний сард 348, зарлага 413 тэрбум төгрөг болж төсвийн тэнцэл 64 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад орлого 2.6%, зардал 54% өсөв. Зарлагын өсөлтөд бараа үйлчилгээний зардал 13%, зээлийн үйлчилгээний зардал 3 дахин, татаас ба шилжүүлэг 50%, мөн дотоод эх үүсвэрээр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт 75 дахин өссөн нь нөлөөлжээ.



Гадаад худалдааны алдагдал 15.9 сая ам.долларт хүрэв.

Нийт барааны эргэлт 2014 оны 1 дүгээр сард 658.3 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.6% буурсан байна. Экспорт 321.2 сая ам.долларт хүрч 14.1% өссөн бол импорт 337.1 сая ам.долларт болж 32.3% буурснаас гадаад худалдааны алдагдал 15.9 сая ам.долларт хүрэв. Нүүрсний экспорт өмнөх оны мөн үеэс 30% буурсан бол, зэсийн баяжмал 34% өссөн байна.




Төгрөгийн ханш сулрав

Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш энэ сард 1,714.26 төгрөгт хүрч өмнөх сарынхтай харьцуулахад 2.4%, өнгөрсөн оны мөн үеэс 23.1% суларсан үзүүлэлт юм. Гадаад валютын албан нөөц 2 тэрбум 446 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн сарынхаас 8.8% өссөн бол өнгөрсөн оны мөн үеэс 40.1% буурсан байна.



Инфляц 12.3%

Улсын хэмжээнд тооцсон инфляцийн жилийн түвшин 12.3% хүрэв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгжээр бага үзүүлэлт юм. Оны эхнээс инфляц 1.7% өсөхөд хүнсний бараа, ундаа, ус болон тээврийн үнийн өсөлт нөлөөлөв. Жилийн 12.3% хүрэхэд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн дүнгийн өсөлтөөс гадна орон сууцны үнэ, мөн боловсролын үйлчилгээ өссөн нь голлон нөлөөлж үзүүлэв.




Эх сурвалж: УЦХ, МБ

САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ


Мөнгөний нийлүүлэлт (M2) 10 их наяд төгрөг

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 36.6% нэмэгдэж, өнгөрсөн сарынхаас 6.1% өсөж 10 их наяд төгрөг (5.8 тэрбум ам.доллар) болжээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 20.5%, өмнөх сарынхаас 6.3% нэмэгдэж 894.3 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 8.9%-ийг эзэлж байна.




Валютын хадгаламж өссөж байна

Хадгаламжийн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 39.3%, өмнөх сарынхаас 7.6% өсөж 6.8 их наяд төгрөгт (3.92 тэрбум ам.доллар) хүрэв. Нийт хадгаламжийн 4.9 их наядыг төгрөгийн хадгаламж, үлдсэн 1.9 их наядыг валютынх эзэлж байна. Төгрөгийн хадгаламж өмнөх сарынхтай харьцуулахад 1.1%, харин валютынх 29.2% тус тус өсчээ.



Чанаргүй зээлийн хэмжээ өссөн хэвээр

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 2.3%, харин өнгөрсөн оны мөн үеэс 54.2% нэмэгдэж, 11 их наяд төгрөг (6.4 тэрбум ам.доллар) боллоо. Чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оныхоос 89.4%, өмнөх сараас 2.8% өсөж 582 тэрбум төгрөг буюу нийт зээлийн 5.3% эзэлж байна. Банкуудын төгрөгийн зээлийн хүү (жилийн, жигнэсэн дундаж) өмнөх жилийнхтэй адил 18.9%, валютынх өнгөрсөн оны мөн үеэс 1.2 нэгжээр буурч 12.4% болов.



Эх сурвалж: УСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > УИХ-аас Төрөөс баримтлах эрдэс баялгийн бодлогыг батлав. Энэхүү бодлого нь хувийн хэвшилд түшиглэсэн ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацааны эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний эрх ашгийг хангахад чиглэнэ. Бодлогын баримт бичиг 4 бүлэг, 14 хэсэг, 70 заалтаас бүрдэж байгаа юм.
- > УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. Уг хуулийн төсөлд Монгол банкинд алтаа тушаасан нөхцөлд нөөц ашигласны төлбөр буюу роялтиг 2.5% тооцох тухай тусгажээ.
- > Монгол Улс Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтанд идэвхитэй оролцлоо.
- > Тариаланчдад үндэсний үйдвэрт тушаасан буудайн тонн тутамд 100,000 төгрөгийн урамшуулал олгож эхэллээ. Нийт 25 тэрбум төгрөгийн урамшууллын санхүүжилтийг 800 орчим иргэн, аж ахуйн нэгжид олгох юм байна.

Хураангуй

2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын эдийн засаг 11.7% өсөлттэй гарсан боловч төгрөгийн бусад валюттай харьцах жилийн нэрлэсэн ханш тасралтгүй суларсаар инфляцийн жилийн түвшин ч 12.3% хүрэв. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өртөг өсөж хэрэглэгчдэд дарамт учруулж мөн хүлээгдэж буй бодит ашиг өдрөөс өдөрт буурч буй нь хөрөнгө оруулагчдын хувьд таагүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

Бусад хүчин зүйлс тогтвортой байгаа нөхцөлд эдийн засгийн өсөлт инфляцийг хөөрөгдүүлдэггүй боловч хэт өндөр өсөлт, мөн зах зээл дээрх мөнгөний хэмжээний тогтмол өсөлт эрэлтийг дэвэргэж улмаар үнийг хөөрөгдүүлсэн байх бололцоотой.

Сүүлийн 3 жилийн турш эдийн засаг дунджаар 13.9% өндөр өсөлттэй байсны зэрэгцээ M2 мөнгө энэ хугацаанд дунджаар 33%, харин гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 23% өссөн юм. Ер нь ажилгүйдлийн түвшин дорвитой буураагүй үйлдвэрлэлийн бүтээмж төдийлөн өсөөгүй тул эдийн засаг бодит өсөлттэй гарч улмаар түүнийгээ хадгалж чадна гэж хэлэхэд бэрх юм. Манай улсын хувьд мөнгөний нийлүүлэлтийн өсөлт хэт өндөр, бүтээмж догуур тул инфляци ч өндөр байна.

2014 оны эхний сарын байдлаар гадаад худалдааны нийт барааны эргэлт 658.3 сая ам. долларт хүрч өмнөх оны мөн үеэс 15.6% буурав. Гадаад орнуудтай хийдэг худалдааны баланс алдагдалтай хэвээр байна. Нэмүү өртөг шингээгүй түүхий эд экспортлодог манай улсын экспорт бага зэрэг өсч технолги мэдлэг шингэсэн өндөр өртөгтэй бэлэн бараа бүтээгдэхүүний имдорт багасчээ.

Сүүлийн жилүүдэд дотоодын цахилгаан эрчим хүч, халаалт, ус гэх мэт нэн чухал бүтээгдэхүүн үйлчилгээний өртөг хямд байхын сацуу хэрэглэгчдийн орлого өсөх тусам импортын тансаг хэрэглээний бэлэн бараа бүтээгдэхүүн ихээр хэрэглэж ирсэн юм. Тиймээс алдагдал хүлээж буй дэд бүтцийн салбаруудын үйлчилгээний үнийг чөлөөлж ашигтай болгох мөн гадагш чиглэсэн мөнгөний урсгалыг багасгах хэрэгтэй.